

Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зар

[Админ](#) 2024-09-03

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Хүсэлт
- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/
- Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх
- Сахилгын шийтгэлтэй эсэх тодорхойлолт
- Төрийн албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалт өгсөн нотлох баримтыг хавсаргах.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн 17.00 цаг хүртэл

- Хүлээн авах хаяг: Жагсаалтад бүртгэлтэй тухайн байгууллагын цахим шуудангаар бичиг баримтаа бүрэн бүрдүүлэн илгээнэ.
- Нийгмийн даатгалын газар: orhon@ndaatgal.mn Холбоо барих утас: 99262089

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛД ШИЛЖҮҮЛЭН АВАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Сул орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод			
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
1	Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар		Цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	гүйцэтгэх	T3-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Эрх зүй /0421/ -багш, мэдээлэл зүйн боловсрол /011403/ -Эдийн засаг /0311/ -социологи болон соёл судлал /0314/ -сэтгүүл зүй /0321/ -нягтлан бодох бүртгэл, татвар /0411/ -санхүү, банк, даатгал /0412/ -менежмент ба удирдахуй /0413/ -маркетинг, зар сурталчилгаа /0414/ -математик /0541/ -өгөгдлийн сан, сүлжээний загварчлал/дизайн/ба удирдлага /0612/ -программ хангамж, түүний хэрэглээ хөгжүүлэлт ба шинжилгээ /0613/		Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.;
2	Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар	Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасаг	Нэг цэгийн үйлчилгээний байцаагч, мэргэжилтэн	1	гүйцэтгэх	T3-9	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	-Эрх зүй /0421/ -багш, мэргэжлийн /0114/ -Эдийн засаг/0311/ -нягтлан бодох бүртгэл, татвар/0411/ -санхүү, банк, даатгал/0412/ -менежмент ба удирдахуй/0413/ -маркетинг, зар сурталчилгаа/0414/ -худалдаа/0416/		Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.;

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ